itools

# КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

# ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ




## +27.5%

**НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**

2020 оны хагас жилийн борлуулалтын орлого (дата төв, тендерийн орлого) өмнө оны мөн үеэс 27.55%-ийн өсөлттэй байлаа.

## +58.75%

**НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ББӨ**

Борлуулалтын орлого өсөнөөс хамааралтай.

## -18.01%

**НИЙТ ЦЭВЭР АШИГ**

Тендерийн борлуулалтын зардал өссөн.

**+74.67%**
**БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**

**+235.26%**
**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ББӨ**

**+135.07%**
**ЦЭВЭР АШИГ**

# ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ (ДАТА ТӨВ)

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ



# АШИГТ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ




EPS Нэгж хувьцаанд ногдох ашиг




P/E Үнэ ашгийн харьцаа




ROA Нийт хөрөнгийн өгөөж




ROE Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж

# ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ



# СТАТИСТИК

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

### ДАТА

Ай дата төвд нийт 430 ТБ дата өгөгдөл хадгалагдаж байна.

### БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Нийт бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо 8599 хүрээд байна.

### АРИЛЖАА

ITLS хувьцаа арилжаанд оролцон өдрийн тоо 234.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 2019 оны эцэст 1284

### ХАРИЛЦАГЧ, ХЭРЭГЛЭГЧ

Нийт харилцагч, хэрэглэгчийн тоо 7790 буюу өмнөх оноос 26.8%

### БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

Борлуулсан бүтээгдэхүүний тоо өмнөх оны мөн үеэс 18.8 %-ийн өсөлттэй .

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ ( 2020 ОНЫ ХАГАС ЖИЛ)

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Систем инженерчлэл монгол”-ийн залуусийн санаачлан хэрэгжүүлж байгаа Skywalker буюу “Бионик гар” нийгмийн төслийн 5 дахь оролцогч 8 настай Г.Адъяа охинд шинэхэн гартай болоход нь тусалж, мөнгөн дэмжлэг үзүүллээ. Skywalker төсөл нь хөдөлгөөний бэрхшээлтэй, хөдөлгөөн хязгаарлагдмал хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжин, бие даах чадварыг сайжруулж, нийгэм соёлын амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь туслах зорилттой нийгмийн төсөл билээ.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ОНЛАЙН ХУРАЛ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн “COVID-19” коронавируст халдвар дэгдсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цугларуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах зэргээр ээлжит хурлыг өөрийн онцлогт тохирсон боломжтой хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй гэсэн мэдэгдлийн дагуу “Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15 цагт онлайнаар амжилттай танилцуулагдлаа.

2020.01 | 2020.02 | 2020.03 | 2020.04 | 2020.05

### ICS ҮЙЛЧИЛГЭЭ

МУ-ын анхны олон нийтийн үүлэн технологид суурилсан ICS үйлчилгээ нь 2019 оны 9-р сард нээлтээ хийсэн билээ. Бид тус үйлчилгээг санхүүгийн байгууллагууд, боловсролын салбарлуу болон старт ап байгууллагуудад чиглүүлэн, хамтран ажиллаж байна.

### ICS MEET

“Айтүүлс” ХК болон “Фибо Глобал” ХХК хамтран “ICS MEET” гэх шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлтийн ажлыг хийж, зах зээлд гаргахад бэлэн болоод байна. Тус аппликейшин нь онлайнаар нэгэн зэрэг 200 - 300 хүн холбогдож видео болон дуун уулзалтийг хийх боломжтой үндэсний хэмжээний анхдагч онлайн хурлын аппликейшин юм. Тус аппликейшин нь үүлэн технологид суурилагдснаас гадна дотоодоо байршиж буй нь тасалдалгүй хурдан ачааллах томоохон давуу талыг үүсгэж байгаа юм. Уг апп-ийг Андройд болон iOS аль алин дээр хэрэглэж болох бөгөөд 2020 оны 4-р улиралд нээлтэй хийхээр төлөвлөж байна.

### МОДУЛЯР ДАТА ТӨВ

Дархан хотод байрлах дэд бүтэц нь бүрэн шийдэгдсэн, ашиглалтад бүрэн орсон “Айтүүлс” ХК-ийн эзэмшилд буй барилга байгууламжид 2020 оны 3-р улиралд “Модуляр дата төв” ашиглалтад орохоор төлөвлөгдөн, ажиллаж байна. Тус газар зүйн нөөц байрлалд Модуляр дата төвийн паркыг ашиглалтанд оруулснаар нийгэм эдийн засгийн бүхий л салбарын компаниудад дэлхийн жишигт нийцсэн цахим мэдээллийн дамжуулалт, хадгалалтын үйлчилгээг үзүүлж тэдгээрийн ашиг орлого, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх эдийн засагт болон мэдээлэл технологийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулахад энэхүү төслийн зорилго чиглэгдэж байгаа юм.